



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/143

Ховд


Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 5/07 дугаар “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Олон угсаатны өв соёлыг өвлүүлэн хөгжүүлэх” аяны хүрээнд 1000 хөөмийч, 1000 уртын дууч, 1000 биелээч, 400 морин хуурч бэлтгэх арга хэмжээнд 41,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Арга хэмжээнд зарцуулагдах 41,000,000 төгрөг /дөчин нэгэн сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.8-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 17-ны өдрийн
А/143 дугаар захирамжийн
хавсралт

ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Сургалт явуулах хүн	Бэлтгэх арга хэмжээ	Зарцуулагдах төсөв /төгрөг/
1	Б.Алтансүх	1000 уртын дууч	3,000,000
2	Ц.Бадамсамбуу	1000 уртын дууч	3,000,000
3	Г.Амаржаргал	100 морин хуурч	3,000,000
4	П.Насан-Очир	100 морин хуурч	3,000,000
5	Б.Галбадрах	100 морин хуурч	3,000,000
6	Д.Мөнхсүх	100 морин хуурч	3,000,000
7	Д.Уламбаяр	1000 биелээч	7,000,000
8	М.Болормаа	300 биелээч	3,000,000
9	Д.Золзаяа	1000 хөөмийч	7,000,000
10	Ч.Баатарсүрэн	400 хөөмийч	3,000,000
11	Х.Ганзориг	400 хөөмийч	3,000,000
Нийт			41,000,000

-oOo-